

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/219

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Аюушжав (Мал эмнэлэгийн улсын байцаагч)
Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
Г.Бямбагарав 5 дугаар багийн Засаг дарга
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, гэрээнд заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (П.Аюушжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

